STUDIA ARCHAEOLOGICA
institute of Archaeology, Mongolia Academy of Sciences
DOI: https://doi.org/10.5564/sa.v45i2.3780

Tomus XLV 2024 Fasciculis 1

Дашзэвэгийн Базаргүр[1]✉, Цэдэндоржийн Болорбат[1], Гөөнийн Лхүндэв[1], Бямбаагийн Гүнчинсүрэн[1], Даваахүүгийн Одсүрэн[1, 2], Энэбишийн Донойдугар[1], Сарантуяагийн Далантай[2]

[1]Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн
Монгол Улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр
[2]Монгол Улсын Боловсролын Их сургууль, Түүхийн тэнхим
Монгол Улс, Улаанбаатар-210648,Сүхбаатар дүүрэг,Бага тойруу-14

Баянцагаан уулын палеолитын дурсгал: 2023 оны малтлага судалгааны урьдчилсан үр дүн

Хураангуй. Монгол орны том голуудын нэг Туул голын сав нутагт 1949 оны үед чулуун зэвсгийн дурсгал байгааг илрүүлэн тэмдэглэсэн ба 2018 оноос эхлэн дурсгалуудыг бүртгэх, баримтжуулах ажил хийгдсэн. 2022 оноос "Туул голын эхэн биеийн чулуун зэвсгийн дурсгалууд" суурь судалгааны төслийн хүрээнд Туул голын дагуу Сонгино уулаас Туул, Тэрэлж голын бэлчир хүртэл нутагт хайгуул болон малтлага судалгааг хийж гүйцэтгээд байна. Энэ хүрээнд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор нутагт Баянцагаан уул хэмээх жижиг уулын зүүн урд талын 8 – 10 м өндөр дэнж дээр хийгдсэн малтлага судалгааны ажлын эхний үр дүнг танилцуулж байна. Баянцагаан ууланд хийсэн малтлагаар палеолитын үед холбогдох 4 соёлт давхарга байгааг тогтоон, 149 ш чулуун зэвсгийн зүйл олж илрүүлсэн. Олдвор хэрэглэгдэхүүн дунд леваллуагийн төрхийн үлдэц, ялтас цуулахад зориулсан үлдэц, хянгар зэвсэг, хүнхэр иртэй зэвсэг, хосолмол иртэй зэвсэг нь дурсгалын он цаг, үйлдвэрлэлийн аргыг тодруулах боломжийг олгож байна.

Түлхүүр үг: *Дээд палеолит, Туул гол, залтсан зэвсэг, ялтсан цуулалт, леваллуагийн арга.*

Dashzeveg Bazargur[1]✉, Tsedendorj Bolorbat[1], Guunii Lkhundev[1], Byambaa Gunchinsuren[1], Davaakhuu Odsuren[1,2], Enebish Donoi-dugar[2], Sarantuya Dalantai[1]

[1]Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia
[2]Department of History,
Mongolian National University of Education
Ulaanbaatar-210648, Sukhbaatar, Baga toiruu-14

The open-air site of bayantsagaan mountain: Preliminary result from the 2023 excavation

Abstract. Research on stone tools in the Tuul River basin began in the 1949s, but there has been little subsequent investigation until 2018, when new efforts commenced to identify stone age sites in the river's headwaters. In 2022, as part of the research project *Stone age Sites of the Tuul River*, archaeological survey and excavation

© Д.Базаргүр, Ц.Болорбат, Г.Лхүндэв, Б.Гүнчинсүрэн, Д.Одсүрэн, Э.Донойдугар, С.Далантай 2024
Email: dbazaraa06@gmail.com, https://orcid.org/0000-0003-2183-0591

were conducted in the area from Songino Mountain near Ulaanbaatar to the confluence of the Tuul and Terelj Rivers along the Tuul River. The goal of these efforts was to reassess previously discovered Paleolithic sites and identify new ones. Here, we present the initial findings from an excavation on the southeast terrace of Bayantsagaan Mountain, located within the Gorkhi-Terelj National Park. The excavation revealed four cultural layers associated with the Paleolithic period, yielding 149 stone tools. Among these tools were Levallois cores, blade cores, side-scrapers, notched tools, and combination tools, providing a comparative framework for dating the site against other Paleolithic sites in the region.

Keywords: *The Upper Paleolithic, Tuul river, Flake tool, Blade core, Levallois method.*

Удиртгал

Монгол орны чулуун зэвсгийн үеийн судалгаа Хангай, Хэнтий, Говь-Алтайн нуруу, тэдгээрийн салбар уулс, говь, хээрийн бүс нутагт өргөн хүрээнд хийгдэж байна. Эдгээр бүс нутгаас чулуун зэвсгийн үеийн дурсгалын судалгаа бага хийгдсэн бүс нутаг бол Хэнтийн нурууны баруун өмнөд хэсэгт орших Туул голын эхэн бие орчмын бүс нутаг юм. Хэнтийн нурууны баруун өмнөд талаас эх авсан Туулын сав хөндий дагуу 1949 онд Монгол-Зөвлөлтийн Түүх-этнографийн хамтарсан экспедицийн бүрэлдэхүүнд А.П.Окладниковын удирдсан "Чулуун зэвсгийн дурсгал судлах" анги хайгуул судалгааны ажлыг хийжээ [Окладников, 1954: 23]. Үүний дараа 1960-1966 онд А.П. Окладников, Д. Дорж нарын удирдсан Монгол, Зөвлөлтийн археологичдын бүрэлдэхүүнтэй "Монголын чулуун зэвсгийн дурсгал судлах" анги Улаанбаатар хотын ойролцоо Сонгино уул, Буянт Ухаа, Шар хадны дэнжээс цөөн тооны палеолитын үед хамаарах чулуун зэвсгийг олж түүвэрлэн цуглуулсан байна. Эдгээр Сонгино уулын дурсгал, Буянт-Ухаагийн дэнж дурсгалын түүвэр олдворын талаар Д. Дорж, Д. Цэвээндорж нар "Монголын палеолит" бүтээлдээ тодорхойлон бичсэн байна [Дорж, Цэвээндорж, 1978: 12]. 2018 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн судлаач Д.Базаргүр, Г.Лхүндэв нар Горхи-Тэрэлжийн нутаг Туул голын дэнж дагуу болон Өвөр горхины аманд хайгуул судалгааны ажлыг хийж, голын эрэг дагуу плейстоцены үеийн давхарга байгааг тогтоож, авто замын ажил хийгдэх явцад энэ давхаргаас чулуун зэвсгийн зүйлс ил гарсан байгааг илрүүлсэн юм. Улмаар Өвөр Горхины аманд байрлах Агуйт хад (Зуун ламын агуй) агуйд бага зэрэг туршилтын малтлага хийж, соёлт давхаргатай агуйн дурсгал болохыг тогтоосон байдаг [Базаргүр нар., 2019: 22-26]. 2020 онд ШУТИС (Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль)-ийн судлаачид "Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалууд" төсөлд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Чулуун зэвсгийн судалгааны салбарын судлаач Д.Базаргүр оролцон ажиллаж Горхи-Тэрэлжийн бүс нутгаас чулуун зэвсгийн үед холбогдох дурсгалуудыг шинээр илрүүлж бүртгэсэн байна [Ванчигдаш нар., 2021: 136]. 2023 онд БШУЯ-ны ШУТС-аас хэрэгжүүлж буй "Туул голын эхэн бие орчмын чулуун зэвсгийн дурсгалууд" суурь судалгааны төслийн хүрээнд 20 гаруй дурсгал шинээр илрүүлэн олжээ [Базаргүр нар., 2023: 60-61]. Туул голын хөндийгөөс өнөөгийн байдлаар олон газраас газрын хөрсөн дээрээс чулуун зэвсгийн үеийн олдвор хэрэглэгдэхүүн олж илрүүлээд байна. Энэ нь эртний хүн амьдарч байсан гэдгийг нотлох хэдий ч аль цаг үед холбогдохыг зөвхөн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн аргаар тодорхойлдог учир бүрэн мэдээлэл авахад хомс юм. Тийм учраас энэ бүс нутагт хөрсөн доор соёлыг хадгалсан давхаргатай дурсгалыг олж илрүүлэх зорилгоор Туул голын баруун гар талаас цутгах Горхи хэмээх голын адагт байрлах Баянцагаан уулын бэлийн өмнө хэсгийн дэнж дээр сорилын малтлага судалгааг 2023 онд хийж гүйцэтгэсэн юм.

Газарзүйн орчин. Баянцагаан уул дурсгалын байршил геоморфологийн хувьд Монгол орны томоохон нуруудын нэг Хэнтийн уулсын бүсэд хамаарах ба Хэнтийн уулс нь геологийн тогтцын хувьд баруун урдаас зүүн хойш чиглэсэн томоохон ан цав хагарлуудаар хэрчигдсэн, тектоникийн мужлалын хувьд төв хэсгээрээ хожуу палеозой буюу девон-карбон, хойд талаараа рифейн эх газарлаг бүрдэл, захын салбар уулсаараа эртний каледонийн бялхмал, эх газрын карбонатлаг хөмбөн цулдам уулсаас тогтдог байна [Цэгмид, 1954: 72]. Хэнтийн уулс нь мезозойн үеэс эхлэн тогтож хөгжсөөр Альпийн тектоникийн идэвхжилээр өргөгдөж одоогийн дүр төрхийг

олж, плейстоценийн эхэн үе гэхэд одоогийн дүр төрхдөө орсон гэж үздэг [Хан Хэнтий, 2010: 19]. Энэ бүс нутгийн тогтцыг боржин, хүрмэн чулуу, шаварлаг занар, элсэн чулуу голлон бүрдүүлдэг байна. Эдгээр үндсэн чулуулгийг бүрхэж тархсан цэрдийн эринд үүссэн цайвар саарал өнгийн элсжин, зануужин, гуравдагчийн улаан, улаавтар шар өнгийн хайргатай элсэрхэг болон наанги шавар, шавранцар, элсний нимгэн үе бүхий хурдас цутгал голуудын дагуу болон адаг, бэлчирт элбэг тохиолдох ажээ. Ялангуяа Туул, Тэрэлж голын хөндийг дагаж тархсан дөрөвдөгчийн буюу голоцены настай элс, хайрга, шавар, хайргажин зэрэг хурдас нэн элбэг юм [Энхтайван, 2004: 27; Нарангэрэл, 2007: 128]. Тайгын цэвдэгт хөрс ихэнх газрыг нь эзэлнэ. Үүнийг судлаачид олон жилийн цэвдэг чулуулаг бүхий Дорнод Сибирийн хөвч тайгад тархсан хэв шинжийн хөрсний үргэлжлэл гэж үздэг. Хэнтийн нурууны баруун өмнөд Бага Хэнтийн салбар уулсын бүсэд Туул голын эхэн бие болон түүнд цутгадаг Заан гол, Тэрэлж гол, Баруун, Зүүн Баян гол зэрэг голууд хамаарна. Туулын савд хамрагдах голуудын хөндийн онцлог шинж нь уул зүйн чиглэл, түүний өндөр нам, чулуулгийн тогтоц байдлаас болж хэлбэр дүрсийн хувьд өөр өөр байдалтай ажээ. Ихэнх гол, горхиудын хөндий эх хэсэгтээ нарийхан, төдий л гүн биш байх бөгөөд харин адаг руугаа өргөн уужим болно. Энд хөрс хуримтлал их явагдах ба Туул гол, түүний томоохон цутгал Тэрэлж голд цутгах Заан голын адагт аллюви, аллюви-пролювийн хурдас зузаан хуримтлагдсан байдаг. Ийм төрлийн хурдас Горхи-Тэрэлжийн нутаг Туул голын баруун биеийн уулын энгэр, голын өндөр дэнж дээр илүү тод ажиглагдана.

Баянцагаан уулын дурсгал бол Туул голын баруун гар талаас Горхи гол цутгах бэлчрийн баруун биед байрлана (Зураг 1.). Горхи гол уулын зүүн талын хормойгоор ороож баруун урагш Туул голд цутгана. Баянцагаан уулын баруун тал бага зэргийн налуу өндөртэй хэрчигдсэн дэнж бүхий тогтоцтой бол бидний сонгож малтлага судалгаа хийсэн газар бол уулын зүүн урд энгэрийн 8 – 10 м өндөртэй, уулын хажуугийн тэгш гадаргуу үүсгэсэн дэнж юм. Энэ дэнжийн нурсан хэсэгт том хад чулуу их байх ба түүний цайвар саарал өнгийн, карбонат ихтэй хөрснөөс чулуун зэвсгийн хагархай, залтас олдож байв.

Судалгааны арга зүй. Малтлага судалгааг уулын зүүн өмнө талын дэнж дээр 3 х 1 м хэмжээтэй талбайг сонгон малтсан. Хөрсний давхаргыг тодорхойлохдоо геологийн хурдас хамгийн сүүлд хуримтлагдсан давхаргыг нэг хэмээн дээрээс доош дугаарлан гүйцэтгэсэн болно. Давхарга тус бүрийн дээд, доод хязгаарыг тогтоон хэмжилт хийж, хөрсний бүтцийг тодорхойлон чулуун зэвсэг илэрсэн байршлыг нарийвчлан тогтоож тэмдэглэв. Эндээс илэрсэн чулуун зэвсгийн тоо ширхэг, төрөл зүйлийг ангилан тоон үзүүлэлтийг гаргасан ба харин олдвор хэрэглэгдэхүүний хувьд давхаргаас илэрсэн анхдагч цуулалтыг илтгэх үлдэц, залтас, ялтас болон зэвсгийн төрөлд хамаарах эдлэлд дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгааны хэрэглэгдэхүүн. Баянцагаан уулын чулуун зэвсгийн дурсгалын малтлага судалгааны явцад гурван соёлт давхаргын 149 ширхэг чулуун зэвсгийн зүйлс судалгааны эх хэрэглэгдэхүүн юм (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл.

Давхарга	Үлдэц		Залтас		Ялтас		Хагархай, хэлтэрхий		Зэвсэг		Σ	%
	N	%	N	%	N	%	N	%	N	%		
2	0	0	1	0.67	0	0	0	0	0	0	1	0.67
3	0	0	56	37.58	13	8.72	26	17.4	5	3.3	100	67.1
3А	0	0	4	2.68	0	0	12	8.0	0	0	16	10.74
4	2	1.34	10	6.71	4	2.68	8	5.36	3	2.0	27	18.1
5	0	0	5	3.35	0	0	0		0	0	5	3.35
Бүгд	2	1.34	76	51.0	17	11.4	46	30.8	8	5.3	149	100

Дурсгалын малтлага, давхарга зүй. Баянцагаан уулын урд энгэрийн хормой хэсэг дэх 8 – 10 м өндөр дэнжид дээд плейстоценийн давхарга хадгалагдан байгаа нь түүний нурсан эргээс тодорхой мэдэгдэж байв. 2023 онд нурсан эргийн ирмэгээс хойд зүг рүү 30 м зайд тэгш гадаргуу бүхий хэсэгт 3 х 1 м хэмжээтэй талбайд малтлага хийсэн. Малтлагаар геологийн 6 давхарга илэрснээс 3-р давхарга, 3А давхарга, 4-р давхарга, 5-р давхаргаас чулуун зэвсгийн зүйл олдож байв. Чулуун зэвсгийн олдвор 1,3 м гүн хүртэл илэрч олдож байсан бөгөөд үүнээс доош 40 см буюу 1,7 м гүнд хүртэл малтахад ул хөрсний хагарч бутарсан чулуу ихсэж, зарим хэсэгт ул хад илэрсэн тул малтлагыг зогсоосон юм.

Дурсгалын хөрсний давхаргыг дараах байдлаар тодорхойлон үзсэн болно (Зураг 2-3.).

1-р давхарга. Энэ давхарга хар хүрэн өнгөтэй, дээд хэсгээрээ сийрэг, доод хэсгээрээ бутарсан чулуулаг ихтэй. 10 – 25 см зузаантай.

2-р давхарга. Давхаргын дээд хэсэгтээ тод хүрэн өнгөтэй бол доод хэсгээр чулуу багатай, нягтаршил ихтэй, бүдэг хүрэн өнгөтэй, нарийн ширхэгтэй хөрснөөс бүрдэл болно. Ийм төрлийн хөрс Рашаан хадны дурсгалын дээд давхаргад хамаардаг ба неолит, хүрэл зэвсгийн үеийн олдвор хэрэглэгдэхүүн илэрдэг бол эндээс ямар нэг олдвор илрээгүй. 20 – 30 см зузаантай.

3-р давхарга. Цайвар цагаан шаварлаг, нарийн ширхэгтэй, жижиг чулуу ихтэй, доод хэсгээрээ чигжирсэн хайрганаас тогтох ба хайрганд том, жижиг хайрга их хэмжээтэй байна. Эндээс чулуун зэвсгийн олдвор олон тоотой олдсон юм. Давхаргын дээд болон доод хэсэгт бүтцийн хувьд ижил ба дундуураа байгаль, цаг уурын огцом хуурайшилтаас үүссэн судал тодорхой мэдэгдэж байгаа учир давхаргын дээд талыг 3, доод талыг 3а хэмээн дугаарлан үзсэн. Энэ 3а давхарга талбайн төв хэсэгт буюу А2 талбайгаас илрээгүй ба энэ хэсэгт усны нөлөөгөөр хуримтлагдсан хайрга, дайрган давхарга байна. Давхаргын доод хэсэг том чулуу ихтэй. Дээд үе нь 30 – 45 см, доод үе нь 5 – 15 см зузаантай.

4-р давхарга. Цагаан саарал шаварлаг хөрстэй, дотроо нарийн ширхэгтэй, бутарсан бичил чулуу ихтэй. 3-р давхаргын доод үед илэрсэн хайрган үе энэ давхаргад мөн үргэлжлэн хоёр тийш өргөссөн байна. Олдворын тоо хэмжээ дээд давхаргыг бодвол цөөрч байна. 25 – 35 см зузаантай.

5-р давхарга. Шаргал, саарал өнгө холилдсон элсэрхэг, бутарсан чулуу ихтэй хөрс учир маш их хатуурсан бүтэцтэй. Хайрга, элс холилдсон судал үүсгэх ба зарим хэсэгт бага хэмжээний шаварлаг хөрс ажиглагдана.

Хайрган давхарга. Энэ давхарга тусдаа бие даасан давхарга гэж үзэж болох юм. Учир нь 5, 4, 3а давхаргуудыг хамарсан байх ба усны нөлөөгөөр үүссэн гэж үзэх боломж байна. Зузаан нь А1 талбайд 50 см, А2 талбайд 100 см зузаантай. Энэ давхаргаас ихэвчлэн хагархай, хэлтэрхий, бичил залтас олдсон ба аль нэг давхаргад хамаатуулан үзэх боломжгүй юм.

6-р давхарга. Ул хад бүхий давхарга.

Дурсгалын олдвор, олдворын хэв шинж

Дурсгалын дөрвөн соёлт давхаргаас 149 ш чулуун зэвсгийн зүйлс, 3 ш ясны хэсэг илэрсэн. Эдгээрийг давхарга тус бүрээр нь авч үзвэл:

3-р давхаргад голын хайрган чулууг түүхий эд болгон ашигласан нийт 100 ш чулуун зэвсгийн зүйл, 1 ш тодорхой бус ясны хэсэг байна. Анхдагч цуулалтыг илэрхийлэх үлдцийн төрлийн эдлэл байхгүй ба залтас 56 ш, ялтас, ялтсан цуулдас 13 ш, үйлдвэрлэлийн явцад хагарч цуурсан хагархай болон цуулдас 26 ш, зэвсгийн төрөлд үзүүр мэс, хянгар зэвсэг, хүнхэр иртэй зэвсэг, хосолмол иртэй зэвсэг, иртэй ялтас илэрч олдсон. Үзүүр мэс нь леваллуагийн жижиг хэмжээтэй үлдцээс цуулж авсан байх ба ар талд нь анхдагч үзүүр мэс цуулахад зориулан бэлтгэсэн нь мэдэгдэнэ (Зураг 4.6). Хянгар зэвсэг нь леваллуагийн аргаар цуулан авсан залтасны нэг хажуу ирмэгийг хэлбэрт оруулан засаж бэлтгээд, зэрэгцээ цуулалтаар нарийн ир гаргаж хийжээ. Цохилтын талбайгаас үзэхэд зууван дугуй хэлбэрийн үлдцээс цуулсан байх ба нүүрэн талдаа цохилтын товгор бага үүссэн байдал нь зөөлөн цохиур ашигласныг илтгэнэ (Зураг 4. *4*). Хянгар зэвсэг хийсэн залтасны цуулалтын байдлаас үзэхэд дээд палеолитын үеийн зэвсэг үйлдвэрлэлд ажиглагддаг леваллуагийн аргаар цуулалт хийгдсэн нь энэ дурсгалын үйлдвэрлэлийн аргыг тодруулах нэг чухал хэрэглэгдэхүүн болох юм. Хүнхэр иртэй зэвсгийг хоёрдогч залтас ашиглан хийжээ. Залтасны суурь хэсгийн нимгэн талд хүнхэр байдлаар цуулалт хийж хэлбэрт оруулаад дахин бичил цуулалтаар ир гаргасан байна (Зураг 4. *8*). Хосолмол иртэй зэвсэг байгаа ба богино ялтасны үзүүр хэсэгт нэг цохилтоор хүнхэр ир

гаргасан бол зэрэгцээ цуулалтаар сийлүүрийн ир гаргажээ (Зураг 4. *15*).

Баянцагаан уулын малтлагаас илэрч олдож буй олдворуудаас үзэхэд анхдагч цуулалтын төрөлд байгаа залтас, бичил залтас, хагархай зэрэг нь үлдцийг засах явцад гарсан хэмээн үзэж болохоор байна. Энэ давхаргаас 13 ш ялтас (Зураг 4. *10, 13-14*) олдсон ба дийлэнх буюу 61,5% нь ялтасны хэсгийн хугархай байна. Бүтэн ялтсыг дунд хэсгээр нь хугалж зэвсэг болгон ашиглах арга Хангайн нурууны өмнөд хэсэг Түйн голын дурсгал [Цэрэндагва, 1998: 21], Хангайн нурууны Цацын эрэг [Гантулга нар, 2023], Эмээлт толгой [Bolorbat et al., 2023: 499-500], Орхон-1 [Хаценович и др., 2018: 174-178], Хэнтий нурууны Ханан [Цогтбаатар, 1994: 47-56], Рашаан хад [И Сонбуг нар., 2019], Зүүн өмнөд тал хээрийн бүс нутгийн Оцон цохио [Odsuren et al., 2023: 1-41] зэрэг дурсгалд ажиглагддаг ба ялтсан зэвсгийн гол төлөөлөл нь Говийн Алтайн нурууны Чихэн агуй [Деревянко и др, 2001: 25-39], Сэлэнгэ голын дунд урсгал орчмын Төлбөрийн голын дурсгал [Гладышев и др, 2013: 82-85; Гунчинсүрэн и др., 2010: 5-31], Эгийн голын Дөрөлжийн дурсгал [Лхүндэв, 2019: 26, 84] юм. Тиймээс эдгээр дурсгалуудтай үйлдвэрлэлийн хувьд ижилсэнэ хэмээн үзэж байгаа ба цаашид энэ давхаргын он цагийг тодруулснаар улам тодорхой болно хэмээн үзэж байна.

Дурсгалын 3А-р давхаргын хувьд 4 ба 3-р давхаргын засварын үе давхарга юм. Эндээс 4 ш залтас, 12 ш хагархай, хэлтэрхий олдсон нь магадгүй дээд, доод давхаргын аль нэгээс шилжсэн байх магадлалтай.

4-р давхаргаас 25 ш чулуун зэвсгийн зүйлс, 2 ш ясны хугархай жижиг хэсэг олдсон. Чулуун зэвсгийн олдворын анхдагч цуулалтад леваллуагийн үлдэц, ялтас цуулах зориулалт бүхий үлдэц, залтас 10 ш, ялтас 4 ш, үйлдвэрлэлийн явцад гарсан хагархай хэлтэрхий 8 ш, зэвсгийн төрөлд хянгар зэвсэг, хусуур зэвсэг, иртэй залтас багтана. Леваллуагийн үлдэц нь хайрган чулууны нэг талыг төв рүү чиглэсэн цуулалтаар засаж бэлтгэсэн байх ба үүний өргөн талд тууш болон хөндлөн цуулалтаар цохилтын талбайг засаад эсрэг тал руу цуулалт хийсэн нь мэдэгдэх ажээ. Цуулалтын гадаргууг зэрэгцээ цуулалтаар товгор байдлаар бэлтгэж, эндээс анхны цуулалтаар тэгш хэмтэй үзүүр мэс цуулсан ул мөр хадгалагдан үлдсэн байна. Цуулалтын гадаргууд хагарал явагдсан учир дараагийн шатны үзүүр мэс цуулах боломжгүй болжээ (Зураг 4. *1*), ялтас цуулах зориулалт бүхий үлдэц нь эсрэг орших цохилтын хоёр талбайтай бөгөөд голоор нь тууш цуулаад үзүүр хэсэгт бага зэргийн ир гаргасан байна. Үлдцийн нэг хажуу талын цуулалтын гадаргууд сөргүүлсэн цуулалтын ул мөртэй. Үлдцийг голоор нь цуулсны дараа үүссэн товгорыг дахин боловсруулалт хийж, нимгэлэн зассан нь харуул зэвсэг болгон ашиглах боломжтой болгожээ (Зураг 4. *2*). Залтаснууд дунд 40 ≤ 50, 50 ≤ хэмжээтэй 4 ш залтасны ар талд зэрэгцээ цуулалт хийсний дараа хөндлөн болон ташуу цуулалтын ул мөр байгаагаас үзэхэд богино өргөн залтас цуулахад чиглэгдэж байсныг илтгэнэ (Зураг 4. *11, 12*). Мөн цохилтын олон талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдцээс хоёр залтас цуулж авсан нь ар талдаа төв рүү чиглэсэн цуулалтын ормуудаас мэдэгдэх ажээ. Хянгар зэвсгийг богино өргөн залтас ашиглан хийсэн байх ба түүний суурь хэсгийг хагас саран хэлбэртэйгээр дугуйруулан засаад, дараагийн шатад босоо зэрэгцээ байдлаар дарж цуулах аргаар ирлэсэн байна (Зураг 4. *5*). Хусуур зэвсгийг ар талдаа хэд хэдэн зэрэгцээ цуулалтын ул мөртэй, нүүрэн талдаа нэг удаагийн хүчтэй цуулалтаар бий болсон цохилтын товгортой өргөн залтсаар хийжээ. Мөн залтасны үзүүр хэсгийн нимгэн талд хөндлөн цуулалтаар сийлүүр зэвсгийн ир гаргасан байна (Зураг 4. *7*).

4-р давхаргын олдвор хэрэглэгдэхүүн хэдийгээр цөөн тоотой байгаа ч чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн аргад үндэслэн аль үед холбогдохыг тодруулах боломж харагдаж байгаа юм. Эндээс олдсон леваллуагийн төрхийн үлдцийг манай орны Говийн Алтайн нурууны Цагаан агуй [Деревянко и др., 1998: 136, 138], Чихэн агуй [**Деревянко и др.,** 2008: 2-12], Арц Богд [Деревянко и др., 2001: 83], Сүүж [Деревянко и др., 2000: 139], Цахиуртын хөндий, Нарийн гол [Деревянко и др., 2000: 53-102], Олон нуур, Барлагийн гол, Үенч, Манхан [Деревянко и др., 1990: 254, 325, 366, 398-404, 428-435], Хангайн нурууны Мойлтын ам [Деревянко и др., 2010: 150; Хаценович и др., 2018:169-173], Хэнтий нурууны Рашаан хад [Базаргүр., 2014: 5-20], Их Хайлант [Цогтбаатар, 2003: 57-67], Ханзат-1 [Izuho, Tsogtbaatar, 2007] зэрэг дурсгалын леваллуагийн хэв шинж бүхий олдвортой төстэй хэмээн

үзэж болохоор байна. Эдгээр дурсгалын он цаг тодорхой болсон бөгөөд Мойлтын ам 32,460±620 (36,400 – 33,250 кал. л.н.) [**Хаценович и др, 2019: 269-275**], Рашаан хад 35,630±180 (41,340~40,353 calBP at 95.4%) [И Сонбуг нар, 2019] буюу дээд палеолитын эхэн үед холбогдох учир Баянцагаан уул дурсгалыг дээрх үед хамаатуулан үзэх саналтай байна. Тус дурсгалаас илэрсэн цөөн тооны зэвсгүүд дунд буй хянгар зэвсэг нь дээд палеолитын үед нийтлэг ашиглагдаж ирсэн зэвсэг юм. Зэвсгийг хийхдээ эхний шатад хэлбэрт оруулаад дараа нь босоо ирлэсэн байдлаас үзэхэд дээд палеолитын эхэн үеэс дунд үед холбогдох болов уу хэмээн таамаглаж байна. 5-р давхаргаас нийт 5 ширхэг олдвор илэрсэн нь бүгд залтас юм. Эдгээр залтсыг ямар төрлийн үлдцээс цуулан авсныг тодорхойлох боломжгүй ажээ.

Дүгнэлт

Баянцагаан уулын дурсгалд малтлага судалгаа хийж, Монгол орны Хэнтийн нурууны баруун өмнөд хэсэг буюу Туул голын эхэн биеийн сав газарт чулуун зэвсгийн олдвор агуулсан соёлт давхарга бүхий дурсгал байгааг тогтоосон нь чулуун зэвсгийн судалгаанд чухал ач холбогдолтой судалгаа болсон. Монгол орны дээд палеолитын үеийн хүний шилжилт хөдөлгөөн нь Алтайн нурууны зүүн өмнөд зүг рүү, Говийн Алтайн уулс, улмаар зүүн зүгт Хангайн нурууны өмнөд болон төв хэсгээр Орхон, Тамирын голыг дамжин нүүдэллэсэн байх магадлал өндөр бөгөөд Орхон, Тамирын гол дагуу нүүдэллэсэн эртний хүн зүүн тийш Туул голыг өгсөн ирж улмаар Хэнтийн нурууны өмнөд талаар тойрч зүүн хойш тархан суурьшсан [Zoljargal, Bazargur., 2023:] хэмээн таамаглаж болохоор байна. Үүнийг нотлох чулуун зэвсгийн дурсгал Туул голын эхэн бие орчмоос олон тоотой илэрч байгаа гэж үзэж болно. Баянцагаан дурсгалын олдворуудыг дээд палеолитын эхэн үеэс төгсгөл шат хүртэл хамаатуулан үзэж болох ба 3 ба 4-р давхаргаас олдсон амьтны яс хадгалалтын байдлаас үзэхэд эртний байж болох учир эдгээр ясны он цагийн шинжилгээ хийлгэж, төрөл зүйлийг тодруулснаар илүү их мэдээлэл олж авах боломжтой. Тус дурсгалаас анхдагч цуулалтыг илэрхийлэх үлдэц цөөн илэрсэн хэдий ч леваллуагийн арга болон дээд палеолитын дунд шатад ихээхэн нэвтэрсэн эсрэг орших цохилтын талбайтай, сөргүүлсэн зэрэгцээ цуулалт бүхий үлдэц, мөн дээд палеолитын эхэн үед гарч ирсэн шовх хэлбэрийн үлдцээс цуулж авсан уртавтар техникийн цуулдас зэрэг нь эртний хүний чулуун зэвсэг үйлдвэрлэлийн шат дараалыг нөхөн сэргээх боломжийг олгож байна. Зэвсгийн төрөл зүйлээс үзэхэд ч энэ бүс нутагт эртний хүн удаан хугацаанд суурьшиж ирснийг илтгэх ажээ. Туул голын эхэн бие орчмоос Баянцагаан уулын дурсгалаас холгүй голын дэнж, мөн Туул голд цутгах том, жижиг голуудын сав газраас олон тооны чулуун зэвсгийн олдвор түүвэрлэж цуглуулсан бөгөөд эдгээр газрууд ч соёлт давхаргатай байх боломжтой гэдэгт бүрэн найдаж байна. Баянцагаан уулын чулуун зэвсгийн дурсгал бол дунд, дээд палеолитын чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн шилжилтийн асуудал, эртний хүний нүүдлийн зам мөрийг тодруулахад эрдэм шинжилгээний хувьд ач холбогдолтой юм.

Талархал. Энэхүү өгүүллийг БШУЯ[1]-ны Шинжлэх ухаан, технологийн сангийн захиалгат “Туул голын эхэн биеийн чулуун зэвсгийн үеийн дурсгалууд” суурь судалгааны ШУТБИХЗГ (Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хэрэгжилтийг зохицуулах газар) – 2022/201 тоот төслийн хүрээнд бичсэн болно.

Ном зүй

Базаргүр, 2014 – Д. Базаргүр. Рашаан хадны чулуун зэвсгийн ангилал, он цаг, үйлдвэрлэлийн аргыг тодруулах нь. //Acta historica. Tom. XV. Fasc. 1. Улаанбаатар. Тал 5-20.

Базаргүр нар, 2019 – Д.Базаргүр, Г.Лхүндэв, Албан Дефлюр. Горхи-Тэрэлжийн сав газарт хийсэн археологийн мэдээ шалгах, тандалт судалгаа: Агуйт хадны чулуун зэвсгийн дурсгалын малтлага. //Монголын археологи - 2018. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар. Тал 22-26.

Базаргүр нар, 2023 – Дашзэвэг Базаргүр, Гөөний Лхүндэв, Бямбаа Гүнчинсүрэн, Цэдэндорж Болорбат, Даваахүү Одсүрэн, Алтанбаяр Золжаргал. Туул голын палеолитын дурсгалууд. // Төв Ази ба Монголын чулуун зэвсгийн үе: Судалгаа, дурсгалуудын хадгалалт хамгаалалт. ОУЭШХ-ын эмхэтгэл. Улаанбаатар. Тал 60-61.

Ванчигдаш нар, 2021 – Ч.Ванчигдаш, Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, Д.Базаргүр,

[1] Хуучин нэрээр

Г.Анхсанаа, Г.Ариунболд, З.Одбаяр, С.Болормаа, Р.Төгссайхан, Ч.Амарбилэг. *Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалууд*. Улаанбаатар. 436 тал.

Гладышев и др, 2013 – С.А. Гладышев, А.В. Табарев, Б. Гунчинсурэн. О времени появления технологических инноваций в каменном веке Северной Монголии: микропластинчатое расщепление и керамическая посуда. // Гуманитарные науки в Сибири. №2. Стр 82-85.

Гантулга нар, 2023 – Ж.Гантулга, Ч.Ерөөл Эрдэнэ, Ж.Магай, К.Салисис, Г.Лхүндэв, Д.Базаргүр. Хойд Тамирын хөндий дэх малтлага судалгаа. Улаанбаатар. 294 тал.

Гунчинсүрэн и др, 2010 – Б.Гунчинсурэн, С.А.Гладышев, Ц.Болорбат, А.В.Табарев, Д.Одсурэн, А.А.Цыбанков, Т.Т.Чаргынов. Новые данные по изучению многослойного палеолитического памятника Тулбэр-15 в 2009 году. // Археологийн судлал. Tomus (IX) XXIX. Улаанбаатар. Стр 5-31.

Деревянко и др, 1998 – А.П.Деревянко, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, А.Н.Зенин, А.И.Кривошапкин, С.В.Николаев, В.П.Мыльников, Б.Гунчинсурэн, Я.Цэрэндагва. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в 1996. Новосибирск. 327 с.

Деревянко и др., 2001 – А.П.Деревянко, А.И.Кривошапкин, В.Е.Ларичев, В.Т.Петрин. Палеолит Восточных предгорий Арц-Богдо (Южная Гоби). Новосибирск. 150 с.

Деревянко и др, 2001 – А.П.Деревянко, С.А.Гладышев, Д.Олсен, В.Т.Петрин, Я.Цэрэндагва. Характеристика каменной индустрии пещеры Чихэн (Гобийский Алтай) // Археология, этнография и антропология Евразии. № 1 (5). Новосибирск. Стр 25-39.

Деревянко и др., 2000 – А.П.Деревянко, Д.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, А.Н.Зенин, С.А.Гладышев, В.П.Мыльников, А.И.Кривошапкин, Р.У.Ривс, П.Д.Брантингхэм, Б.Гунчинсурэн, Я.Цэрэндагва. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в 1997-1998. Новосибирск. 327 с.

Деревянко и др., 2000 – А.П.Деревянко, В.Т.Петрин, Д.Цэвээндорж, Е.В.Девяткин, В.Е.Ларичев, Р.С.Васильевский, А.Н.Зенин, С.А.Гладышев. Палеолит и неолит северного побережья Долины Озер. Новосибирск, 439 с.

Деревянко и др., 1990 – А.П.Деревянко, Д.Дорж, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин, Е.В.Девяткин, М.Малаева. Каменный век Монголии. Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск. 644 с.

Деревянко и др., 2010 – А.П.Деревянко, А.В.Кандыба, В.Т.Петрин. Палеолит Орхона. Новосибирск. 381 с.

Дорж, Цэвээндорж, 1978 – Д.Дорж, Д.Цэвээндорж. Монголын палеолит. Улаанбаатар. 156 тал.

Zoljargal, Bazargur., 2023 – A.Zoljargal, D.Bazargur. Paleolithic cultures and ancient human migrations in Mongolia. // Studia Archaeologica. Tom.XLII. Fasc. 1. Ulaanbaatar. Тал 5-12. https://doi.org/10.5564/sa.v42i1.2814.

И Сонбуг нар, 2019 – И Сонбуг, Б.Гүнчинсүрэн, Д.Базаргүр, И Жонөн, Г.Эрэгзэн. Монголын Рашаан хадны палеолитын дурсгал. Сөүл. 114 тал.

Лхүндэв, 2019 – Г.Лхүндэв. Эгийн голын хөндийн чулуун зэвсгийн судалгаа. Түүхийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар. 252 тал.

Нарангэрэл, 2007 – С.Нарангэрэл. Туул гол ба түүний томоохон цутгал голуудын хөндийн онцлог, морфометрийн үзүүлэлтүүд. Монгол орны Газарзүйн асуудал. Улаанбаатар. № 5. Тал 128.

Окладников, 1951 – А.П.Окладников. Новые данные по древнейшей истории Монголии. // Вестник древней истории. Москва. №4 (38). Стр 162-174.

Хан Хэнтий, 2010 – Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө. (2010-2015). Улаанбаатар. тал 19.

Хаценович и др, 2018 – А.М.Хаценович, Е.П.Рыбин,Д.Базаргүр,Д.В.Олсен,Б.Гунчинсурэн, Д.В.Марченко, А.М.Клементьев, С.А.Когай, Р.А.Шелепаев, А.Ю.Попов, А.С.Кравцова, Т.А.Шевченко. Хроностратиграфические исследования среднего палеолита на памятнике Орхон-1, Центральная Монголия. // Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. – Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН, 2018. – Т. XXIV. Стр 174-178.

Хаценович и др, 2018 – А.М. Хаценович, Е.П.Рыбин,Д.Базаргүр,Д.В.Олсен,Б.Гунчинсурэн,

Д.В.Марченко, С.А.Когай, А.С.Кравцова, Р.А.Шелепаев, Я.Ю.Шелепов, Т.А.Шевченко. Новый цикл исследований на памятнике Мойлтын ам в Центральной Монголии // Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. – Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН, 2018. – Т. XXIV. https://doi.org/10.17746/2658-6193.2018.24.174-178.

Хаценович и др, 2019 – А.М. Хаценович, Е.П.Рыбин, Д.Базаргур, Д.В.Марченко, Дж.Ге, И.Д.Долгушин, Т.А.Шевченко, С.А.Когай, Б.Гунчинсурэн, Дж.У.Олсен. Новая хронология и культурная атрибуция археологических комплексов памятника Мойлтын ам (Центральная Монголия). // Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. – Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН, – Т. XXV. https://doi.org/10.17746/2658-6193.2019.25.269-275.

Цогтбаатар, 1994 – Б.Цогтбаатар. Ханангийн чулуун зэвсгийн дурсгал. Археологийн судлал. Том XIV (3). Улаанбаатар. 47-57.

Цогтбаатар, 2003 – Б.Цогтбаатар. Онон, Хэрлэнгийн сав нутгийн палеолитын судалгаа. //Монгол-Солонгосын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиумын илтгэлийн эмхэтгэл, Улаанбаатар. тал 57-67.

Цэгмид, 1954 – Ш.Цэгмид. Хэнтийская страна в Монголии. Сборник, “Вопросы географии” №35. Улаанбаатар. тал 32-44.

Цэрэндагва, 1998 – Я.Цэрэндагва. Түйн голын хөндийн палеолитын дурсгалуудын он цагийн дурсгалуудын хамаадлын асуудалд. Studia Archaeologica. Tomus XVIII. Fasc.3. Улаанбаатар. Тал 19-26.

Энхтайван, 2004 – Д.Энхтайван. Туул голын сав нутгийн хотгор гүдгэрийн тархалт, онцлог. Монгол орны Газарзүйн асуудал. № 3, Улаанбаатар. Тал 23-32.

Bolorbat et al., 2023 - Tsedendorj Bolorbat, Dashzeveg Bazargur, Guunii Lkhundev, Batsuuri Ankhbayar, Adyasuren Altanbagana, Tsend Amgalantugs, Gonchig Batbold, Cao Jian’en, Song Guodong, Cao Peng, Cai Xi. The northern dispersal route: new evidence of Upper Paleolithic human behavior from the Tsagaan Turuut River Valley, central Mongolia. // Acta Anthropologica Sinica. Vol. 42. Issue 4. Pp 488-502. https://doi.org/10.16359/j.1000-3193/AAS.2022.00076.

Davaakhuu Odsuren et al, 2023 – Davaakhuu Odsuren, Lisa Janz, William Box, Dashzeveg Bukhchuluun. Otson tsokhio and Zuun Shovkh: the Initial Upper Paleolithic in Eastern Mongolia. Journal of Paleolithic Archaeology. 2023. Volume 6. No 10. pp 1- 41. https:doi.org/10.1007/s41982-023-00139-x.

Izuho, Tsogtbaatar et al., 2007 – Izuho M, Tsogtbaatar B, Takuya Yamaoka, Kazuhiro Hayashi, Altangerel Enkhtur. Preliminary Report of Geoarcchaeological Investigation at Khanzat-1, Eastern Mongolia. /Papers from the First International Conference on “Archaeological Research in Mongolia” held in Ulaanbaatar, August 19th-23rd/. Ulaanbaatar. Pp 31-46.

Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.
See: http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/



Зураг 1. Баянцагаан уул дурсгалын ерөнхий байдал, малтлага хийсэн байршил.



Зураг 2. Баянцагаан уул палеолитын дурсгалын хөрсний давхарга



Зураг 3. Баянцагаан уул: Давхарга, олдворын байршил

Хүснэгт 1.

Давхарга	Үлдэц		Залтас		Ялтас		Хагархай, хэлтэрхий		Зэвсэг		Σ	%
	N	%	N	%	N	%	N	%	N	%		
2	0	0	1	0,67	0	0	0	0	0	0	1	0.67
3	0	0	56	37.58	13	8.72	26	17.4	5	3.3	100	67.1
3А	0	0	4	2.68	0	0	12	8.0	0	0	16	10.74
4	2	1.34	10	6.71	4	2.68	8	5.36	3	2.0	27	18.1
5	0	0	5	3.35	0	0	0		0	0	5	3.35
Бүгд	2	1.34	76	51.0	17	11.4	46	30.8	8	5.3	149	100

\



Зураг 4. Баянцагаан дурсгал: 1. Леваллуагийн төрхийн үлдэц (Levallios core), 2. Ялтас цуулсан үлдэц (Blade core), 3. Техникийн цуулдас (Technical spall), 4-5. Хянгар зэвсэг (Side scraper), 6. Үзүүр мэс (Point), 7. Хусуур зэвсэг (Scraper), 8. Иртэй залтас (Retouched flake), 9. Хүнхэр иртэй зэвсэг (Notched tool), 10. Цуулдас (Spall), 11-12. Залтас (Flake), 13-14. Ялтас (Blade), 15- Хосолмол иртэй зэвсэг (Combination tool).